



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 03 сарын 09 өдөр

Дугаар 69

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3, 44 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 4.4 дахь заалт, “Мэдээ тайлангийн маягт батлах тухай” 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монголросцветмет” төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 432,674,148.04 (дөрвөн зуун гучин хоёр сая зургаан зуун далан дөрвөн мянга нэг зуун дөчин найман төрөг дөрвөн мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хоёр удаагийн нээлттэй дуудлагын худалдаанд оролцогч ирээгүй, 20 ширхэг автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоосугай.

2. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Нандинжаргал, “Монголросцветмет” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Б.Мөнхбатад дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Дуудлагын худалдааг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулах, дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих журмын дагуу байгууллагын дансанд төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Энэ арга хэмжээний биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримтын хамт 2021 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

13201020

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 03 дугаар сарын 09 өдрийн
69 дугаар тогтоолын хавсралт

**"МОНГОЛПРОСЦВЕТМЕТ" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ҮНДСЭН
ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР
ХУДАЛДАХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ**

№	Тээврийн хэрэгслийн марк, улсын дугаар, зориулалт, арлын дугаар	Ашиглалтад орсон огноо	Балансын үнэ		Худалдах доод үнэ /төгрөг/
			нэг бүрийн үнэ /төгрөг/	нийт үнэ, хуримтл агдсан элэгдэл /төгрөг/	
1	2	3	4	5	6
1	Хүнд даацын автомашин Комацу НР325, арал: HD325- 6-5727	1998/01/01	205,958,413.54	205,958,413.54	44,500,000.00
2	Автосамосвал ХОВО ZZ 3257 47-36 арал: LZZ5ELMD38A288270	2008/03/01	53,546,629.50	53,546,629.50	2,000,000.00
3	Ачааны машин Камаз 5511 67-арал: 582135979	2001/01/01	27,400,000.00	27,400,000.00	1,000,000.00
4	Ачааны машин Камаз 5410 80-арал: 711022277	2002/01/01	7,200,000.00	7,200,000.00	1,500,000.00
5	Ачааны машин Краз 6510 29- 33 арал: 10791767	2001/01/01	38,222,100.00	38,222,100.00	1,500,000.00
6	Ачааны машин Краз 6510 №91-16 ДГА арал: 790774	2002/12/31	12,798,333.00	12,798,333.00	900,000.00
7	Ачааны машин Кран краз №77-73 ДГА арал: 1856891	1990/12/31	1,133,500.00	1,133,500.00	6,000,000.00
8	Ачааны машин МаЗ ТЦ-8 67- 50 ДГ арал: А95039	1997/01/11	5,400,000.00	5,400,000.00	4,500,000.00
9	Зил-130 5тн №77-72 ДГА арал: 3335392	1990/12/31	2,581,875.00	2,581,875.00	250,000.00
10	ГАЗ 52 ПРМ 16- 2040081006724	1988/01/01	1,161,000.00	1,161,000.00	350,000.00
11	Автобус ЛАЗ-677 16-26 арал: 148674	1986/01/01	204,000.00	204,000.00	400,000.00
12	Автобус ЛАЗ-677 16-31 арал: 171408	1989/01/01	204,000.00	204,000.00	400,000.00
13	Автобус ПАЗ 3205 22-63 арал: 95005664	1995/01/01	9,900,000.00	9,900,000.00	200,000.00

1	2	3	4	5	6
14	Автогрейдер ДЗ 112 45-22 арал:178893	1988/01/01	4,826,250.00	4,826,250.00	2,000,000.00
15	Чиргүүл ОДА39370 арал: 42569	2002/01/01	1,000,000.00	1,000,000.00	2,000,000.00
16	Чиргүүл 39 ПРС110 71-54 арал:У-0005011	1997/01/01	1,000,000.00	1,000,000.00	1,750,000.00
17	Чиргүүл Алка 18-12 арал:180552	1992/01/01	3,500,000.00	3,500,000.00	1,250,000.00
18	Автомашин Исузу 50-86 УБЦ арал:W7289618	2006/01/12	11,540,400.00	11,540,400.00	500,000.00
19	Автомашин Land kruizer 39- 00 УБЛ арал:UZJ1000081386	2001/01/01	41,580,000.00	41,580,000.00	4,000,000.00
20	УаЗ 31514 94-84 ДГА арал:10011444	2001/01/01	3,517,647.00	3,517,647.00	250,000.00
	НИЙТ ДҮН			432,674,148.04	75,250,000.00
			(дөрвөн зуун гучин хоёр сая зургаан зуун далан дөрвөн мянга нэг зуун дөчин найман төрөг дөрвөн мөнгө)		(далан хоёр сая хоёр зуун тавин мянга)